

## САНХҮҮГИЙН АУДИТ ТАЙЛАН

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: СБА-2024/158-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор:	Г. Даваа
Баруун-Урт хот	Утас:	Цахим хаяг: davaag@audit.gov.mn
2024 он	Аудитын менежер:	М.Нарантуяа
	Утас:	Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn
	Ахлах аудитор:	Л.Оюунбилэг
	Утас: 99206951	Цахим хаяг: auditor1@mindig.mn
	Миндуг аудит ХХК-ийн захирал:	С.Энхтөр
	Утас:	Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>3</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН</b> .....	<b>5</b>
<b>3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>8</b>
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>11</b>

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН ОНГОН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ц.БАТТӨМӨР ТАНАА

2024.02.25 № 136  
танай \_\_\_\_\_ - ны № \_\_\_\_\_ -г

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Сүхбаатар аймгийн Онгон сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус асуудал үүсээгүй, хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн.

2023 онд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 59.4 сая төгрөг, төсөв захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,626.9 сая төгрөгийн санхүүжилт олгож, 1,503.3 сая төгрөг буюу 92.4 хувийг зарцуулж, мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 183.0 сая төгрөг байна.

## **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудитын чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Тус сургууль 1-5 ангийн сурагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гаргасан гүйцэтгэлийн зөрүү, төсвийн үлдэгдлээс 1.5 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж, 24.1 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Онгон сумын Ерөнхий боловсролын сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр 6 зорилтын хүрээнд 51 арга хэмжээ төлөвлөж 87.4 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>127,439,127.15</b>	<b>252,956,517.51</b>
<b>31</b>	<b>Мөнгөн хөрөнгө</b>	<b>59,356,510.21</b>	<b>183,031,182.58</b>
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	59,356,510.21	183,031,182.58
31210	Төгрөг	59,356,510.21	183,031,182.58
31211	Төрийн сангийн харилцах	59,356,510.21	183,031,182.58
<b>35</b>	<b>Бараа материал</b>	<b>68,082,616.94</b>	<b>69,925,334.94</b>
35400	Хангамжийн материал	63,507,116.94	66,770,334.94
35410	Бичиг хэргийн материал	-	990,672.00
35420	Аж ахуйн материал	45,706,923.71	46,837,519.71
35460	Хүнсний материал	1,771,600.00	1,507,000.00
35470	Бусад ханамжийн материал	16,028,593.23	17,435,143.23
35600	Мал амьтад	4,575,500.00	3,155,000.00
<b>2.</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>839,601,115.02</b>	<b>2,516,965,213.27</b>
<b>39</b>	<b>Үндсэн хөрөнгө</b>	<b>839,601,115.02</b>	<b>2,500,931,379.81</b>
39200	Биет хөрөнгө	783,991,115.02	2,461,655,213.81
39201	Барилга байгууламж орон сууц	826,838,100.00	2,464,802,938.00
39202	Хуримтлагдсан элэгдэл-Барилга	(187,476,851.28)	(264,264,717.60)
39203	Авто тээврийн хэрэгсэл	19,800,000.00	00.00
39204	Хуримтлагдсан элэгдэл-Тээврийн хэрэгсэл	(10,175,000.00)	00.00
39205	Машин тоног төхөөрөмж компьютер	172,124,686.00	322,881,525.54
39206	Хуримтлагдсан элэгдэл-Тоног төхөөрөмж	(75,111,119.05)	(113,343,240.39)
39207	Тавтлга аж ахуйн эд хогшил	50,135,344.00	89,475,344.00
39208	Хуримтлагдсан элэгдэл-Тавилга	(17,389,066.85)	(43,138,324.34)
39214	Бусад үндсэн хөрөнгө	100,000.00	100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл-Бусад үндсэн хөрөнгө	(255.80)	(3,611.40)
39217	Номын фонд	5,145,300.00	5,145,300.00
39300	Биет бус хөрөнгө	55,610,000.00	55,310,000.00
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл- Программ хангамж	(100,000.00)	(400,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	54,210,000.00	54,210,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>967,040,242.17</b>	<b>2,769,921,731.33</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>555,073.00</b>	<b>00.00</b>
<b>41</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>	<b>555,073.00</b>	<b>00.00</b>
41300	Өглөг	555,073.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	555,073.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>966,485,169.17</b>	<b>2,769,921,731.33</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>966,485,169.17</b>	<b>2,769,921,731.33</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	522,082,593.56	522,082,593.56
51102	Өмч: - Төрийн	522,082,593.56	522,082,593.56
51200	Хуримтлагдсан үр дүн	36,466,152.97	1,839,902,715.13
51210	Өмнөх үеийн үр дүн	(930,019,016.20)	36,466,152.97
51220	Тайлант оны үр дүн	966,485,169.17	1,803,436,562.16
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	407,936,422.64	407,936,422.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН</b>	<b>967,040,242.17</b>	<b>2,769,921,731.33</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,427,090,272.44</b>	<b>3,594,700,976.54</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>930,153,541.44</b>	<b>1,795,703,676.54</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>930,153,541.44</b>	<b>1,795,703,676.54</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,333,400.00	4,871,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,443,400.00	4,871,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,890,000.00	-

120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө	851,407,974.50	1,785,629,072.54
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан материал	66,412,166.94	4,739,022.00
120009	Бусад орлого	-	464,082.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,496,936,731.00</b>	<b>1,798,997,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,263,093,300.00</b>	<b>1,626,895,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,263,093,300.00	1,626,895,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>233,843,431.00</b>	<b>172,102,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,843,431.00	172,102,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,460,585,103.27</b>	<b>1,783,839,414.38</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,460,585,103.27</b>	<b>1,783,839,414.38</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,357,764,053.66</b>	<b>1,708,102,585.46</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>938,727,738.56</b>	<b>1,155,185,828.83</b>
210101	Үндсэн цалин	677,506,432.05	811,338,830.42
210102	Нэмэгдэл	210,029,460.39	300,855,654.41
210104	Урамшуулал	51,191,846.12	42,991,344.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>107,363,921.23</b>	<b>144,648,442.80</b>
210201	Тэтгэврийн даатгал	73,512,640.60	98,900,532.80
210202	Тэтгэмжийн даатгал	8,609,957.19	11,600,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,881,245.76	9,269,241.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,669,097.02	2,368,104.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,690,980.66	22,510,152.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>155,201,590.39</b>	<b>162,394,833.08</b>
210301	Гэрэл, цахилгаан	8,578,966.39	12,267,739.08
210302	Түлш, халаалт	146,192,624.00	149,881,094.00
210303	Цэвэр, бохир ус	430,000.00	246,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>-</b>	<b>6,777,704.00</b>
210408	Бараа материал акталсны зардал	-	6,777,704.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,938,480.00</b>	<b>32,526,918.00</b>
210502	Хоол, хүнс	24,938,480.00	32,526,918.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,278,200.00</b>	<b>4,218,300.00</b>
210604	Урсгал засвар	4,278,200.00	4,218,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,217,490.00</b>	<b>14,685,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,443,400.00	4,871,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,774,090.00	9,813,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>115,036,633.48</b>	<b>187,665,458.75</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,499,213.00	35,375,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,369,180.00	9,016,980.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	66,168,240.48	143,272,578.75
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>102,821,049.61</b>	<b>75,736,828.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>80,550,840.00</b>	<b>71,029,662.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	264,082.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	80,550,840.00	70,765,580.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>22,270,209.61</b>	<b>4,707,166.92</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,270,209.61	4,707,166.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>966,505,169.17</b>	<b>1,810,861,562.16</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>20,000.00</b>	<b>7,425,000.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	20,000.00	7,425,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>7,425,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>966,485,169.17</b>	<b>1,803,436,562.16</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>1,509,270,131.00</b>	<b>1,804,332,882.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>12,333,400.00</b>	<b>5,335,582.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	12,333,400.00	5,335,582.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	12,333,400.00	4,871,500.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,443,400.00	4,871,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,890,000.00	-
120009	Бусад орлого	-	464,082.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,496,936,731.00</b>	<b>1,798,997,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,263,093,300.00	1,626,895,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,263,093,300.00	1,626,895,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	233,843,431.00	172,102,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	233,843,431.00	172,102,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,395,532,239.79</b>	<b>1,638,225,604.63</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,395,532,239.79</b>	<b>1,638,225,604.63</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,290,280,240.18</b>	<b>1,562,707,405.71</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	938,172,665.56	1,155,740,901.83
210101	Үндсэн цалин	677,506,432.05	811,338,830.42
210102	Нэмэгдэл	210,029,460.39	300,855,654.41
210104	Урамшуулал	50,636,773.12	43,546,417.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	107,363,921.23	144,648,442.80
210201	Тэтгэврийн даатгал	73,512,640.60	98,900,532.80
210202	Тэтгэмжийн даатгал	8,609,957.19	11,600,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,881,245.76	9,269,241.01
210204	Ажилгүйдлийн даатгал	1,669,097.02	2,368,104.40
210205	Эрүүл мэндийн даатгал	16,690,980.66	22,510,152.59
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	155,201,590.39	162,394,833.08
210301	Гэрэл, цахилгаан	8,578,966.39	12,267,739.08
210302	Түлш, халаалт	146,192,624.00	149,881,094.00
210303	Цэвэр, бохир ус	430,000.00	246,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	23,999,380.00	32,480,948.00
210502	Хоол, хүнс	23,999,380.00	32,480,948.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,999,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	4,999,000.00	5,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,217,490.00	14,685,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,443,400.00	4,871,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,774,090.00	9,813,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	48,326,193.00	47,757,180.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,365,893.00	36,623,795.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,960,300.00	11,133,385.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>105,251,999.61</b>	<b>75,518,198.92</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	82,981,790.00	70,811,032.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	264,082.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	82,981,790.00	70,546,950.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	22,270,209.61	4,707,166.92
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	22,270,209.61	4,707,166.92
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>113,737,891.21</b>	<b>166,107,277.37</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>54,381,381.00</b>	<b>42,432,605.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>54,381,381.00</b>	<b>42,432,605.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	54,381,381.00	42,432,605.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,381,381.00	42,432,605.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	-	<b>42,432,605.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	59,356,510.21	123,674,672.37
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	59,356,510.21
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	59,356,510.21	183,031,182.58

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	- 114,723,162.16	815,295,854.04
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	- 815,295,854.04	- 815,295,854.04
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	- 930,019,016.20	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	966,485,169.17	966,485,169.17
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	36,466,152.97	966,485,169.17
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	36,466,152.97	966,485,169.17
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	36,466,152.97	966,485,169.17
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,803,436,562.16	1,803,436,562.16
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	522,082,593.56	407,936,422.64	1,839,902,715.13	2,769,921,731.33

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,898,480,000.00	1,675,486,960.71
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,898,480,000.00	1,675,486,960.71
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,803,867,800.00	1,604,940,010.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,291,546,800.00	1,155,540,901.83
210101	Үндсэн цалин	895,056,000.00	811,138,830.42
210102	Нэмэгдэл	348,033,600.00	300,855,654.41
210104	Урамшуулал	48,457,200.00	43,546,417.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	161,443,500.00	144,648,442.80
210201	Тэтгэврийн даатгал	109,781,700.00	98,900,532.80
210202	Тэтгэмжийн даатгал	12,915,500.00	11,600,412.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,332,400.00	9,269,241.01
210204	Ажилгүйдлийн даатгал	2,583,000.00	2,368,104.40
210205	Эрүүл мэндийн даатгал	25,830,900.00	22,510,152.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,506,700.00	162,394,833.08
210301	Гэрэл, цахилгаан	10,900,000.00	12,267,739.08
210302	Түлш, халаалт	186,106,700.00	149,881,094.00
210303	Цэвэр, бохир ус	4,500,000.00	246,000.00
2105	Нормативт зардал	38,048,600.00	32,480,948.00
210502	Хоол, хүнс	38,048,600.00	32,480,948.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	5,000,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	5,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	15,196,800.00	14,685,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	4,871,500.00	4,871,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,325,300.00	9,813,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	91,125,400.00	90,189,785.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	75,637,400.00	74,701,785.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,488,000.00	15,488,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,612,200.00	70,546,950.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	94,612,200.00	70,546,950.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,612,200.00	70,546,950.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,893,608,500.00</b>	<b>1,794,290,133.08</b>
1320	Улсын төсвөөс санхүүжих	1,263,093,300.00	1,626,895,300.00
122005	Орон нутгийн төсвөөс	172,102,000.00	172,102,000.00
132004	Улсын төсвөөс	59,356,500.00	1,454,793,300.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		59,356,510.21
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		183,031,182.58

### **3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 33.6 сая төгрөгийн 3 алдаа<sup>1</sup> илэрснээс 24.1 сая төгрөгт төлбөрийн акт, 9.8 сая төгрөгт албан шаардлага, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 28 нэрийн 169 ширхэг үндсэн хөрөнгийг ОНӨГ-т тавьж шийдвэрлүүлэх асуудлаар зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй алдаа нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага байх тул өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

#### **3.1 Төлбөрийн акт**

##### **Илрүүлэлт:**

Тус сургуулийн 1-5 дугаар ангийн суралцагчдын үдийн хоолны батлагдсан нормативд зардал, хүүхэд өдрөөр гарсан гүйцэтгэлийн зөрүү төсвийн үлдэгдлээс 1.5 сая төгрөгийн хүнсний материал нөөцөлж 24.1 сая төгрөгийг холбогдох дансанд төвлөрүүлэлгүй үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.3-д заасан “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах, Боловсролын ерөнхий хуулийн 38 дугаар зүйлийн 38.4-д заасан “Энэ хуулийн 38.1.2, 38.1.3”-т заасан гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг боловсролын сургалтын байгууллага дараагийн төсвийн жил дамжин зарцуулж болно”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 “нөөцлөх шаардлагатай бараа, материалыг үр ашиггүй удаан хадгалах, шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа материал бэлтгэх, нөөцлөх” гэж заасантай нийцэхгүй байна.

#### **3.2 Албан шаардлага**

Байхгүй.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **3.3 Зөвлөмж**

##### **1. Цалингийн зардалтай холбоотой асуудал**

##### **Илрүүлэлт:**

Бүтэц орон тоогоор батлагдаагүй хөдөлмөрийн аюулгүй байдлын ажилтан, жолооч, слесарь, архивын эрхлэгчийн орон тоог хавсран гүйцэтгүүлсний 20-40%-ийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, 41 дүгээр зүйлийн 41.2.3 “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д заасан “байгууллагын бүтэц чиг үүргийг оновчтой тодорхойлж цалин хөлсийг орлого үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох” гэсэн заалтуудыг зөрчсөн ба иж бүрэн байх, ангилал үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### **Өгсөн зөвлөмж:**

Төсвийн төслөө батлуулахдаа шаардлагатай орон тоогоо зөв төлөвлөж, цалингийн сан батлагдсан тохиолдолд ажил хавсруулах нэмэгдлийг олгох. Орон тоо нь батлагдаагүй ажлын байранд ажил хавсран гүйцэтгүүлэх тушаал гаргахгүй, ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулан тухайн ажил үүргийг гүйцэтгүүлэхэд анхаарах

## **2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 28 нэрийн 169 ширхэгтэй хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Сангийн сайдын 388-р тушаалын НББ-ийн дансны зааврын 4.39-т заасны дагуу бүртгэл тайланд тусгах, эд хөрөнгийн үнийг зөвшилцөн тогтоох үед УСНББОУС 23 “Арилжааны бус орлого” гэсэн стандартын 42, 44 дүгээр праграфийн дагуу орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх, ашиглалтын хугацаа дууссан ашиглагдахгүй болсон хөрөнгийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "худалдах, шилжүүлэх, устгах эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх", 31.2 "... элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг ТӨБЗ /ОНӨГ/-ын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох" гэж заасны дагуу арга хэмжээ авч ажиллаагүй байна.

### **Өгсөн зөвлөмж**

Элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнээ нөхсөн 28 нэрийн 169 хөрөнгөд дүн шинжилгээ хийж, эд хөрөнгийн байнгын зөвлөлөөр дүн шинжилгээ гаргуулан, цаашид ашиглах тохиолдолд ОНӨГ-т хүргүүлэн дахин үнэлгээ хийлгэж стандартын дагуу бүртгэл тайланд тусгах, ашиглах боломжгүй бол акталж устгах асуудлыг холбогдох журмын дагуу шийдвэрлэж ажиллах

## **3. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

### **Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим системд тайлант онд 159 мэдээлэл байршуулахаас 155 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй, мөн өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан захирлын тушаал шийдвэр, байгууллага иргэнтэй байгуулсан гэрээг байршуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 8.4-д “ Байгууллага албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно” гэж заасантай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг ил тод, үнэн зөв, иж бүрэн хугацаанд нь байршуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сүхбаатар аймгийн Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс											
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн		
Батлагдаагүй орон тоонд хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон	1	9,788.1					1	9,788.1					1	72,977.1
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгө	1						1							
Үдийн цайны үлдэгдлийг төвлөрүүлэх	1	24,065.2	1	24,065.2										
Дүн	3	33,853.2	1	24,065.2	1	9,788.1	1							

##### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны цахим хуудсанд 3 мэдээллийг хугацаа хоцроож, 5 мэдээллийг байршуулаагүй, мөн өмч, хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой гарсан захирлын тушаал шийдвэр, байгууллага иргэнтэй байгуулсан гэрээг байршуулаагүй					1	1
Дүн						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Дүн						
Нийт дүн						